

ХУУЛИЙН ХЭЛТСҮЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ЛУВСАНДОРЖИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Гүйцэтгэлийн түвшин							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	
			3	4			5
Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх							
1	Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт тавьсан байдал Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчид гаалийн хяналт тавих нийтлэг журмыг шинэчлэн боловсруулахад харьяа гаалийн газар, хороодоос болон нэгжүүдээс санал авч эрх зүйн актад нийцүүлж, нэгжийн чиг үүргийн хүрээнд санал, төсөл боловсруулагдсан байх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		1.Гаалийн тухай болон Гаалийн татварын тухай хуулийн төсөлд хорио цээрийн хяналтын үүргийг нэмж, холбогдох судалгаа, тайлбар шинэчлэн боловсруулсан байна.	1. Гаалийн тухай болон Гаалийн тариф, татварын тухай хуулийн дагуу төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээч, амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхийн эд бүтээгдэхүүнийг импортлогч, экспортлогч, тээвэрлэгч, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан санал сонсох, мэдээлэл авах сонгогд зохион байгуулсан, "Сонсгол"-д 41 иргэн аж ахуй нэгжийн төлөөлөл оролцож ЭМЯ, ЗӨСҮТ, МЭЭГ-с санал авч саналыг журмын төсөлд тусгаж ажиллахаар шийдвэрлэсэн. 2. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуультай холбогдуулан "Албан татварын эрх зүйн зохицуулалтад холбогдох зарим хуулийн хуулийн лавлагаа" гаргасан талаар хамтран ажилласан бөгөөд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн Бие даасан хуулийн сангаас 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар судлан үзэхэд татварын харилцааг зохицуулсан салбарын 102 хууль дагаж мөрдөж байна гэж үзэхээр байна. /Хууль зүйн лавлагаа 62 хуудастай/ 3. ГЕГ дээр зохион байгуулагдсан "Татварын хууль тогтоомжийн шинэчлэл" нээлттэй хэлэлцүүлгийн зохион байгуулалтын ажилд хамтран ажилласан бөгөөд ГЕГ-ын	01.01-06.10	100%

				бүтцийн зохион байгуулалтын нэгж болон зарим гаалийн газар, хороодоос ирүүлсэн татварын хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбоотой саналыг тоон үзүүлэлтээр нэгтгэн Сангийн яаманд 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр цахимаар хүргүүлсэн. 4. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн Бие даасан хуулийн сангаас 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар судлан үзэхэд гаалийн албаны үйл ажиллагаанд холбогдох улсын хилийн боомтын үйл ажиллагааг зохицуулсан нийт 38 хуулиас 33 хуудас хууль зүйн лавлагаа гаргахад хамтран ажилласан. 5. "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны төлбөр тооцооны журам"-ын төсөлд 2 санал тус тус өгч ажилласан. 6. ХБГ, МТГ, ЗУХ, СДШХ-с "Чөлөөт бүсийн үйл ажиллагааны мэдээллийн сан, түүнийг ашиглах, мэдээлэл солилцох журам"-ын төсөлд тус хэлтсийн 2025.01.16-ны өдрийн 01200/3 дугаар дотоод зурвасаар санал авч 8 саналыг ГЕГ-ын даргын 2025.01.22-ны өдрийн 01-1.2/361 дугаар албан бичгээр Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн зохицуулагч Э.Золзаяад хүргүүлсэн. 7. ХБГ-ын 20255.01.18-ны өдрийн 01101/126 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн "Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай 1973 оны 3-р сарын 3-ны өдрийн конвенцид заасан зөвшөөрөл (сертификат, лиценз)-ийн мэдээллийг цахим хэлбэрээр солилцох тухай Холбооны гаалийн алба (ОХУ) болон Монгол Улсын ГЕГ хоорондын хэлэлцээр"-т тус хэлтсийн 2025.02.18-ны өдрийн 01200/63 дугаартай дотоод зурвасаар санал өгсөн. 8. ХБГ-ын 2025.02.18-ны өдрийн 01101/133 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын төсөлд 21 саналыг тус хэлтсийн 2025.02.18-ны өдрийн р 01200/64 дугаартай дотоод зурвасаар санал өгсөн. 9. Тус хэлтсийн 2025.02.20-ны өдрийн 01200/67 дугаартай дотоод зурвасаар ЗББН-үүдээс "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүний худалдаанд хяналт тавих тухай хууль"-ийн төсөлд санал авч саналыг нэгтгэн ажлын хэсэгт хүргүүлсэн. 10. БХ-т Эрэнцав (Монгол Улс)-Соловьеск (ОХУ) хоёр талын зэрэглэлтэй, төмөр замын ачаа бараа, зорчигч тээврийн		
--	--	--	--	--	--	--

				боомтыг олон улс (олон талт) зэрэглэлтэй болгож өөрчлөх төсөлд тус хэлтсийн 2025.03.20-ны өдрийн 01200/117 дугаартай дотоод зурвасаар санал өгсөн.		
2	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ Нэгжийн чиг үүргийн хүрээнд захиргааны хэм хэмжээний актад хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, шаардлагатай эрхийн актыг шинэчлэн найруулж, нэмэлт, өөрчлөлт оруулан, олон нийтэд сурталчлах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		1. ГЕГ-ын даргын 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн №А/176 тушаалаар батлагдсан сар бүр мэдээлэл ирүүлэх тухай хавсралтаар гаргасан 7 үзүүлэлтээр ЗУГ-т мэдээлэл авахаар тус хэлтсээс 01200/7 дугаартай дотоод зурвасаар явуулж хамтран ажилласан. 2. Нэгжийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн 2024 он, 2025 оны эхний улирлын үйл ажиллагаанд ХШУДАГ-аас хийсэн дотоод аудитын үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичиг, холбогдох баримт бичгийг гарган хүргэсэн. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд захиргааны хэм хэмжээний актуудын талаар одоогоор судалгааг хийж байна. Холбогдох эрх зүйн актад хяналт, шинжилгээ үнэлгээ хийх эрх зүйн зохицуулалтыг судлан ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор захиргааны хэм хэмжээний актад хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, шаардлагатай эрхийн актыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал гаргахаар хамтран ажиллаж байна. 3. Нийтээр дагаж мөрдөх 31 захиргааны хэм хэмжээний актыг гаалийн харилцаанд оролцогч, судлаач, гаалийн чиглэлээр суралцагч оюутан, түүнчлэн гаалийн албан хаагч нар чөлөөтэй, нээлттэй уншиж судлах, хялбар ашиглах шийдлийг боловсруулахад хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа нийтээр дагаж мөрдөх шинжтэй 31 захиргааны хэм хэмжээний актыг жагсаалтыг баазтай "Link"-ээр холбож, актыг санг "docx" өргөтгөлөөр бэлтгэж дууссан. Цахим санг www.legalinfo.mn "Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем"-ийн хуулийн хэлбэрээр Эрх зүйн акт, хавсралт, нэмэлт, өөрчлөлт гэсэн бүтэц, агуулгаар боловсруулбал нийтээр ашиглаж хэвшсэн хэлбэр, загвар тул хэрэглэхэд хүндрэл бэрхшээлтэй үүсэхгүй.	01.01-12.08	100%
3	Хууль, хяналтын байгууллагад Гаалийн байгууллагыг төлөөлөх, хамтран ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх 31 захиргааны хэм хэмжээний актад Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын хуралдааны 2024 оны 39 дүгээр тэмдэглэлийг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны "Аргачлал батлах тухай" 59 дүгээр тогтоолыг удирдлага болгон	01.01-06.10	100%

			холбогдох хууль тогтоомжид нийцэх буй эсэхэд хяналт тавьж, санал өгсөн байх.	хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд хамтран ажиллаж 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 1/2516 дугаар албан бичгээр 6 хуудас хавсралтыг хүргүүлсэн.		
4	Хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эцсийн жилийн тайланг холбогдох хүргүүлэх,	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Захиргааны, Иргэний болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Гаалийн Ерөнхий Газрын даргын олгосон итгэмжлэлийн үндсэн дээр нэхэмжлэгч, хариуцагч, иргэний хохилогчоор оролцсон талаар, шүүх болон хууль хяналтын бусад байгууллагуудын шийдвэр, хүсэлтийн дагуу шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хамтран ажилласан байна.	Тайлант хугацаанд ГУБ Б.Лувсандоржийн хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, иргэний хохилогч, шүүх болон хууль хяналтын бусад байгууллагуудын шийдвэр, хүсэлтийн дагуу шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд бусад байгууллагаас санал ирээгүй тул оролцоогүй. Харин шүүхэд хянагдаж буй хэрэгт эрх зүйн зөвлөмж өгсөн тухайд 1. "Гэрэлтжин" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Гаалийн ерөнхий газарт холбогдох захиргааны хэргийн хянан шийдвэрлэхэд эрх зүйн зөвлөмж өгч оролцсон бөгөөд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025.01.31-ны өдрийн 128/ШШ2025/0102 дугаартай шүүгчийн захирамжаар хэргийг хэрэгсэхгүй болгосон. 2. Улаанбаатар хот дахь ГТ-г иргэн Ц.Эрдэнэтогтохын нэхэмжлэлтэй, гаалийн улсын байцаагч Б.Одончимэгт холбогдох захиргааны хэргийн хянан шийдвэрлэсэн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024.11.27-ны өдрийн 128/ШШ2024/0948 дугаартай шийдвэрийг эс зөвшөөрч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан давж заалдах томдолод хэрхэн эрх зүйн талаас хэрхэн оролцох чиглэлийг 2025.01.21-ний өдрийн 01-1.2/302 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 3. БЦТ-ийн ГУАБ Г.Сономцэвээн, ГУБ Г.Нарантуяа нарт Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд "Гэрэлтжин" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэл хэрхэн бичих, хариу тайлбар гаргах талаар зөвлөгөө өгч ажилласан. 4. УБГТ-ын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн "Чиглэл хүсэх тухай" №01/51 албан бичигт дурдсан өндөр настны тэтгэвэр тогтоолгосон иргэн төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдсон тохиолдолд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох талаарх холбогдох хууль тогтоомжийг судалж хариуг 2025.01.24-ний өдрийн 01-1.2/396 албан бичгээр хүргүүлсэн.	01.01-06.10	100

				5. 2025.01.27-ны өдөр УБГТ-ын Зөрчилтэй тэмцэх албаны ГУБ Ц.Гэндэнцэвээнтэй уулзаж "Юнайтед белаэ машинери инвестмент" ХХК-ийн нэхэмжлэлтэй Гаалийн ерөнхий газарт холбогдох захиргааны хэрэгт шүүхэд өгөх хариу тайлбар, нотлох баримтын талаар эрх зүйн зөвлөмж өгсөн. 6. БЦТ-ийн ГУБ-д "Санчир-Ундрах" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой эрх зүйн зөвлөмж өгсөн. 7. Улаанбаатар хот дахь гаалийн газрын нэхэмжлэлтэй А.Гантулга /Азийн петролиум ХХК-ийн тухайн үеийн захирагл-аар хугацаа хожимдуулсан нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар, түүний хүү болох нийт 53,250,000 төгрөгийг төлүүлж улсын төсөвт төвлөрүүлэх шаардлага бүхий нэхэмжлэлтэй иргэний хэргийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Гэндэнцэвээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зөвлөмж өгсөн. Шүүх хуралдаанаар нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байдал. Тайлант хугацаанд дараах захиргааны хэрэгт холбогдох нотлох баримт, бичгээр тайлбар өгч, анхан шатны шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаан, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдол, давж заалдах гомдолд хариу тайлбар өгч шүүх хуралдаанд оролцсон. Одоогийн байдлаар 1. "Чонгол трейд" ХХК-ийн нэхэмжлэлтэй БДШГ-ын ГУБ нарт холбогдох захиргааны хэрэг түдгэлзсэн. 2. "Санчир-Ундрах" ХХК-ийн нэхэмжлэлтэй БЦТ, БАХУ, ХХ, ГЕГ захиргааны хэрэг түдгэлзсэн. 3. "Санчир-Ундрах" ХХК-ийн нэхэмжлэлтэй ГЕГ, БАУХ захиргааны хэрэг түдгэлзсэн. 4. Санчир-Ундрах ХХК-ийн нэхэмжлэлтэй БАУХ, БЦТ, ГЕГ-т захиргааны хэрэг түдгэлзсэн. 5. "Лекс ойл" ХХК-ийн нэхэмжлэлтэй ГЕГ-т холбогдох захиргааны хэрэг дууссан. 6. Ч.Дөлгөөнийн нэхэмжлэлтэй ГЕГ-т холбогдох захиргааны хэрэг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 7. "Чоногол трейд" ХХК-ийн нэхэмжлэлтэй ГЕГ, ТОГ, УБГТ, ЧХОУНБГТ, УХШИГТ-т тус тус холбогдох захиргааны хэрэг дууссан.		
--	--	--	--	---	--	--

				8. "Метагро" ХХК-ийн нэхэмжлэлтэй ГЕГ, ТОГ-т холбогдох захиргааны хэрэг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 9. "Юнайтед белаэ" ХХК-ийн нэхэмжлэлтэй УБГГ-т холбогдох захиргааны хэрэг дууссан. 10. "Лекс ойл" ХХК-ийн нэхэмжлэлтэй ГЕГ-т холбогдох захиргааны хэрэг шинээр үүссэн төлөвтэй байна. Харин иргэний хэргийн тухайд 1. Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд Гаалийн ерөнхий газрын нэхэмжлэлтэй "Беруноложистикс ГХО" ХХК-д холбогдох иргэний хэрэг 2. Хөвсгөл аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд Хөвсгөл аймгийн Ханх дахь гаалийн хороо-ны нэхэмжлэлтэй "Валданс" ХХК, "Сант-Өндөр" ХХК иргэний хэрэг тус тус хянагдаж байна.		
5	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах	Хийгдэх ажлын шалтгаан, нөхцөл, суурь үзүүлэлтээр	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.	Тайлант хугацаанд бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж, гүйцэтгэж ажиллаа. Үүнд: 1. "Ахмад гаальчдын Од холбоо" ГҮТББ-ын журмын төслийг боловсруулан хүргүүлсэн. Энэхүү боловсруулсан дүрмийн дагуу ахмад гаальчид "Ахмад гаальчдын Од холбоо" ГҮТББ-ыг байгуулан ажиллаж байна. 2. ХЦХ, ХХ хамтран "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих тусгай шаардлага", "Тээврийн хэрэгсэлд хийгдэх халдваргүйжүүлэлтийн журам"-уудыг Нийтийн сонголын тухай хуулийн дагуу төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээч, амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхийн эд бүтээгдэхүүнийг импортлогч, экспортлогч, тээвэрлэгч, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан санал сонсох, мэдээлэл авах сонгогч зохион байгуулсан. "Сонсгол"-д 41 иргэн аж ахуй нэгжийн төлөөлөл оролцож ЭМЯ, ЗӨСҮТ, МЭЕГ-с санал авч саналыг журмын төсөлд тусгаж ажиллахаар шийдвэрлэлээ. 3. ЗУГ, СХОГ, ХНХ, "Ахмад гаальчдын Од холбоо" ГҮТББ-тай хамтран "Гаалийн байгууллагын ахмадын сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах журам"-ын төслийг боловсруулж МЗХ-д танилцуулж ГЕГ-ын даргын 2025.05.30-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/239 дүгээр тушаалаар батлуулсан.	01.01-06.10	100%

				4. Тус хэлтсийн 2025.01.29-ний өдрийн 01200/28 дугаартай дотоод зурвасаар ЗУГ-г "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг гаалийн байгууллага хэрэгжүүлж, тайлагнах боломжтой эсэх, боломжгүй бол эрх зүйн үндэслэл бүхий тайлбар"-ыг гаргаж өгсөн. 5. Ёс зүйн дэд хороотой хамтран "Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм"-ийн төслийг боловсруулж АТГ, МУ-ын Ёс зүйн хороонд хянуулахаар тус тус хүргүүлсэн. 6. ХБГ-ын 2025.02.25-ны өдрийн 01101/141 дугаартай дотоод зурвастай танилцаж "Мал амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, ариутгал, халдваргүйтэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай" ЗГ-ын тогтоолын төсөлд эрх зүйн зөвлөмж, санал өгсөн. 7. Тус хэлтсийн 2025.02.21-ний өдрийн 01200/69 дугаартай дотоод зурвасаас СХОГ, ХЦХ, БХ-г тус тус Сангийн сайдын "Хэмжилт, шинжилгээ, халдваргүйжүүлэлтийн үнийг батлах тухай" 2018 оны 253 дугаар тушаалын 6 болон 7 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсон тушаалыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг хүргүүлсэн. 8. Тус хэлтсийн 2025.03.06-ны өдрийн 01200/90 дугаартай дотоод зурвасаар ХБГ, ЭУХ, ХЦХ-г тус тус Тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, ухаалаг технологид суурилсан газар тариаланг хөгжүүлэх, хөрсний уржил шимийг хамгаалж, сайжруулах зорилгоор "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатай өрнүүлэхээр шийдвэрлэсэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 47 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг өгсөн. 9. Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн газрын хуралдааны цахим систем/e-sabnet.gov.mn/-ээр МУЗГ-ын 18, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 9, Ерөнхий сайдын захирамж 5 ирсэн. Үүнийг ГЕГ-ын удирдлагад танилцуулж холбогдох ЗББН-д хүргүүлсэн.		
6	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт хангах	Хийгдэх ажлын шалтгаан, нөхцөл, суурь үзүүлэлтээр	Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан талаар тайлагнана.	Хуулийн хэлтсийн гаалийн улсын байцаагч Б.Лувсандоржийн тухайд хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хэлтсийн бүсэд албан хаагч нартай хамтран тайлант хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:	01.01-06.10	100%

				1. Бүгд Найрамдах Беларусь Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 02-05/587 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Бүгд Найрамдах Беларусь Улсын Гаалийн хороо, Монгол Улсын Гаалийн ерөнхий газар хоорондын эдийн засгийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр"-ийн төслийг Гаалийн ерөнхий газрын холбогдох нэгжүүдэд танилцуулж саналыг нэгтгэсэн. Тус хэлэлцээрийн төсөлд тусгасан санал болон Сангийн яамнаас зөвшөөрөл авч хамтран ажиллахыг тус хэлтсийн 2025.01.23-ны 01200/20 дотоод зурвасыг ГХАХ-т хургуулсан. 2. Тус хэлтсийн 2025.01.29-ний өдрийн 01200/30 дугаартай дотоод зурвасаар "Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын гаалийн улсын байцаагч Д.Нямсүрэн, Л.Баасанбат нарын 2023.12.21-ний өдрийн "Илүү төлөгдсөн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг суутган тооцуулах тухай" 03/23 дугаар "Дүгнэлт"-ийг хүчингүй болгосон Гаалийн ерөнхий газрын даргын 2025.01.21-ний өдрийн А/16 дугаар тушаалыг хургуулж "ГУБ нарын БДШ-ын үйл ажиллагаа ГЕГ-ын даргын 2015 оны А/134 дугаартай тушаалаар батлагдсан журам болон ГТХ-ийн 249 дүгээр зүйлийн хүрээнд хийгдсэн ба шалгалтад хамрагдсан ААНБ-д хандан дүгнэлт үйлдэх эрх зүйн зохицуулалт үйлчилж байсан бөгөөд Гаалийн удирдах төв байгууллагын бүтцийн нэгжид хандан дүгнэлт гаргах эрхгүйг анхааран, цаашид дахин ийм төрлийн алдаа гаргах нь ГУБ албаны эрх мэдлээ хэтрүүлсэн үйлдэл болох тул нийт ГУБ нарт анхааруулсан. 3. БЦТ-н 2025.01.28-ны өдрийн "...Бичээч харчу" ХХК-ийн импортлож буй "хийн буу" тоглоомын зориулалттай гэх бараанд бичиг баримтын шалгалт хийхэд аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрөл болон импортын лиценз шаардлагатай эсэх талаар нарийвчлан судлан хууль эрх зүйн зөвлөгөө өгч бидний ажилд дэмжлэг үзүүлэх"-ийг хүссэн 128 дугаартай дотоод зурвас, түүнд хавсаргасан 4 хуудас албан бичгийн хүрээнд судлан үзэж, танилцаад "...Бичээч харчу" ХХК-ийн 12-2201003-24-130075 дугаартай мэдүүлсэн бараа, тээврийн хэрэгслээс өөр бусад галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгсэлд тусгай зөвшөөрөл болон импортын лиценз хууль, тогтоомжийн дагуу шаардлагатай" гэсэн эрх зүйн зөвлөгөөг тус хэлтсийн 2025.02.05-ны өдрийн 1200/40 дугаартай дотоод зурвасаар БЦТ-д өгсөн.	
--	--	--	--	--	--

				4. Хяналт бүрдүүлэлтийн газарт ОХУ-с Монгол улсад суугаа Элчин сайдын яамны Гаалийн ерөнхий газарт ирүүлсэн "Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай 1973 оны 3-р сарын 3-ны өдрийн конвенцид заасан зөвшөөрөл (сертификат, лиценз)-ийн мэдээллийг цахим хэлбэрээр солилцох тухай Холбооны гаалийн алба (ОХУ) болон Монгол Улсын ГЕГ хоорондын хэлэлцээр"-т санал, эрх зүйн зөвлөмжийг тус хэлтсийн 2025.02.18-ны өдрийн 01200/63 дугаартай албан дотоод зурвасаар зөвлөмж өгсөн. 5. ТОГ-т "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн 2016 онд барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар байршуулсан авто бензин, дизель түлшийг 3Г-ын 2024.12.25-ны өдрийн 241 дүгээр тогтоолын дагуу гаалийн бүрдүүлэлтийн "422" горимд байршуулж гаалийн бүрдүүлэлт хийх боломжтой эсэхэд тус хэлтсийн 2025.03.12-ны өдрийн 01200/101 дүгээр дотоод зурвасаар эрх зүйн зөвлөгөө өгсөн. 6. Боомтын хэлтэст "Хилийн боомт болон Монгол-Орос улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн нэгдүгээр хавсралтад "Авто замын боомтоор хил нэвтрэх иргэд 8-аас илүүгүй суудалтай хувийн авто тээврийн хэрэгслээр эсхүл явганаар нэвтэрч болно. Явган зорчигчийг тусгай зурвасаар нэвтрүүлнэ," гэсэн заалт, мөн тус хэлэлцээрийн хоёрдугаар хавсралтад Эрэнцав (Монгол Улс)-Соловьеск (ОХУ) хоёр талын зэрэглэлтэй, төмөр замын ачаа бараа, зорчигч тээврийн боомтыг олон улс (олон талт) зэрэглэлтэй болгож өөрчлөх төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах санал авч буй Олон Улсын гэрээнд тус хэлтсийн 2025.03.30-ны өдрийн 01200/117 дугаартай дотоод зурвасаар хариу өгсөн. 7. Хяналт, бүрдүүлэлтийн газрын 2025.04.11-ны өдрийн 01101/224 дугаартай дотоод зурвасаар Гаалийн тухай хуулийн 246 дугаар зүйлийн 246.7 хэсгийн талаар хууль эрх зүйн зөвлөмж ирүүлэх тухай хүсэлтийн дагуу 01200/167 дугаартай дотоод зурвасаар дараах хариуг хүргүүлсэн. "2008 онд батлагдсан Гаалийн тухай хуульд гаалийн шалгалтыг дахин хийх талаар хоёрдмол утгагүй, нэг мөр ойлгогдох зохицуулалт тусгагдаж гаалийн харицаанд 17 жилийн турш өөрчлөгдөөгүй хэрэгжиж ирсэн байна. Хууль, журамд дахин шалгалтыг хяналтын бүсэд, эсхүл хяналтын бүсээс гарснаас хойш хийх талаар ялгамжтай байдлаар заагаагүй байх тул дахин	
--	--	--	--	---	--

				шалгалтын талаарх зохицуулалт дээрх хоёр нөхцөлийн аль алинд хамаарна гэж үзэхээр байна" гэсэн эрх зүйн зөвлөмжийг өгсөн.		
				9. Тус хэлтсийн 2025.0.5.06-ны өдрийн 01200/216 дугаартай дотоод зурвасаар ГХАХ-т "БНСУ-ын Шинжлэх ухаан, мэдээлэл, технологийн яамны санхүүжилтээр Virect ХХК, Rebellions ХХК болон B2EN ХХК-ийн хамтарсан консорциумын Хиймэл оюун ухаанд суурилсан чатбот болон өргөтгөсөн хайлтын платформын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх мөн хиймэл оюуны технологийн дэд бүтцийг бий болгох тухай харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн төсөлд санал, үг санаамж бичгийг хэрхэн байгуулах талаар эрх зүйн зөвлөмж өгч хууль хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг өгсөн. Тайлант хугацаанд нэгжийн дотоод эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: Ажлын цаг ашиглалтад анхаарч царай таних төхөөрөмжид царайгаа тогтмол таниулж, цагийн бүртгэлдээ анхаарч ажилласан. Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл үүсгэж болох нэг хүчин зүйл болох хууль, журам, заавар аргачлалаар зохицуулаагүй үйл ажиллагаа, хэрэгжүүлэх боломжгүй буюу бодит байдалд үндэслэгдээгүй журам, заавар боловсруулагдсан байх, хууль тогтоомжид нийцээгүй зөрчилдсөн байх, эрхийн актын удиртгал болсон хууль, хуулийн заалт хүчингүй болсон эсэх, ач холбогдлоо алдсан дагаж мөрдөгдөхгүй болсон тушаал, шийдвэр байгаа эсэх дээр байнга хяналт, шинжилгээ хийж ажиллаж байна.		
7	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	-Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Нэгжийн дотоод эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэх ажилд оролцсон байна.	Тайлант хугацаанд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд хуулийн хүрээнд тухай хэрэгжүүлэн ажиглана. Тайлант хугацаанд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд хуулийн хүрээнд тухай бүр хэрэгжүүлэн ажигласан. Үүнд: 1. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт А.Гэрэлмаа, Б.Нацагням, Ц.Одонтунгаал нарын шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой 4 хуудас баримтыг 2025.02.17-ны өдрийн 01-1.2/756 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын 2025.03.11-ний өдрийн 05-02/1434 дүгээр албан бичгээр гаргасан хүсэлттэй танилцаад	01.01-06.10	100%
8	Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	-Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар	-		01.01-06.10	100%

				2025.03.19-ний өдрийн 01-1.2/1082 дугаар албан бичгээр "хүсэлтэд дурдсан мэдээ, мэдээллийг өгөх боломжгүй" гэсэн хариу өгсөн. 3. Иргэн Б.Асралтын гаргасан гомдлын хүрээнд 250 хуудас баримтыг бүрдүүлж холбогдох баримтад хуулбар үнэн тэмдэг даруулж хүргүүлсэн. 4. "Чоногол трейд" ХХК-д 2025.01.02-ны өдрийн 005/25а албан бичигтэй танилцаж "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д "хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэглээнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгсэл" эрх зүйн зохицуулалтын тайлбарыг ГЕГ-ын 2025.01.29-ний өдрийн 02/456 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 5. Өмгөөлөгч Ш.Ерболд ГЕГ-ын 2025.03.06-ны өдрийн 01-1.2/940 дугаар албан бичгээр "Оросын Холбооны Улсаас Монгол Улсад 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд импортоор өндөр оруулж ирсэн иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, холбоо барих утас, өндөгний сорт, нэр, тоо хэмжээ, импортоор оруулж ирсэн огноо, боомтын мэдээ, мэдээллийг гаалийн байгууллагаас гаргаж өгөх боломжгүй болох"-ыг хүргүүлсэн. 6. Цагдаагийн ерөнхий газрын дарга, Гаалийн ерөнхий газрын дарга, Монгол шуудан ХК-ийн гүйцэтгэх захирал нарын хамтарсан 2025.03.10-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/111, А/76, А/32 дугаар тушаал батлагдсан байна. Иймд тушаалын хэрэгжилтийг хангаж ажиглахыг ЗТГ-т тус хэлтсийн 2025.03.1-ний өдрийн 01200/109 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн. 7. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбатад "2020-2024 онуудад гаалийн бүрдүүлэлт хийлгэн оруулж ирсэн нийт автомашин импортологч хуулийн этгээд, иргэдийн нэр, оршин суугаа хаяг, утасны дугаарын мэдээ, мэдээллийг гаалийн байгууллагаас гаргаж өгөх боломжгүй болох"-ыг 2025.03.19-ний өдрийн 01-1.2/1082 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 8. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд "Жи Эм И" ХХК /РД:2748053/-ийн мэдээ, мэдээллийг 2025.04.01-ний өдрийн 01-1.2/1273 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.		
--	--	--	--	--	--	--

				9. “Санчир-Ундрах” ХХК-д ГЕГ-ын 2025.04.25-ны өдрийн 01-1/1715 дугаартай албан бичгээр “БТКУС-ийн Тайлбар дүрмийн 1-д “Хэсэг, бүлэг болон дэд бүлгийн гарчиг нь бараат ангилахад зөвхөн анхан шатны лавлагаа баримжаа болно. Хууль ёсны ангилал нь зүйлийн гарчиг болон холбогдох хэсэг, бүлгийн тайлбараар тодорхойлогдоно” гэж заасан мэдээ, мэдээллийг хүргүүлсэн. 10. “Ган-Илч” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт “2021.10.19-ний өдрийн 11-2091008-21- E00960R, 2021.12.13-ны өдрийн 11-2131009-21-E01211R дугаартай гаалийн мэдүүлгүүдээр гаалийн бүрдүүлэлт хийгдсэн тухай мэдээ, мэдээлүүдийг өгсөн.		
9	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжруулж ажиллаж, үр дүнг тайлагнана.	01.01-06.10	100%
10	Үндсэн шалгуурт тусгадаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр.	-	Үндсэн шалгуурт тусгадаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	01.01-06.10	100%

				"Гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаар томдол гаргах", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас "Гаалийн албан хаагч таны давхар эрхэлж болох ажил", "Гаалийн улсын байцаагч та ажлаас чөлөөлөгдсөн өдрөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсэх тул дараах үйл ажиллагааны мэдээлэл", "Гаалийн улсын байцаагч таны нийтийн албаны ёс зүйн дүрэм", "Энэ хууль тогтоомж зөрчсөн бол хүлээлгэх хариуцлага"-ын гарын авлага, нугалбарын хууль зүйн текстийг бэлтгэн хургуулсан. 4. Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокурор Ц.Ариунболдод ГЕГ-ын 2025.05.29-ний өдрийн 01/2280 дугаартай албан бичгээр Н.Туул, Б.Ганбатын нартай холбоотой захиргааны болон иргэний хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээ, мэдээлэл холбогдох нотлох баримтыг хургуулсан. 5. УБГГ, СэГГ, ЧХОУНБГГ, ЗУДГГ, УХШИГГ-т Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/239 дүгээр тушаалаар "Гаалийн байгууллагын ахмадын сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах журам", мөн оны 05 дугаар сарын 30-ны өдрийн "Ахмад настныг төлөөлж ажиллах ажилтнуудыг томилох тухай" Б/326 дугаар тушаалаар харьяа гаалийн газар, хороодод ажиллах ажилтнуудыг томилж, "Гаалийн байгууллагын ахмад настантай харилцах үйл ажиллагаанд зөвлөх болон туслах үүрэгтэйгээр ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулж ажиллах чиглэлийг хургуулсан. 6. segr.esustoms.mn/-ийн "Үүрэг даалгавар-т ХХ-т 2025 оны хагас жилийн байдлаар 45 үүрэг даалгавар өгсөн. Үүнээс 42 үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн тайлагнаж дүгнүүлсэн. Одоогоор 3 үүрэг даалгаврын биелэлт хугацаа болоогүй байна. 7. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан Гаалийн ерөнхий газрын 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь ЗУГ-т хургуулэн ажиллаж байна.		
11	Байгууллагын улирдалаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн	- Тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянасан,	Байгууллагын улирдалаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн	Тайлант хугацаанд дараах тушаалын төслийг боловсруулж, шийдвэрийн үндэслэлийг хянаж хэрэгжилтийг хангаж ажилласан. Үүнд:	01.01-06.10	100%

Үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах		хэрэгжилтийг хангасан байх - Тайланд нотломжийг хавсаргасан байх	үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах ажилд оролцсон байна.		1. ГЕГ-ын даргын 2025.05.30-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/239, 2. ГЕГ-ын даргын 2025.05.30-ны өдрийн "Ахмад настныг төлөөлж ажиллах ажилтнуудыг томилох тухай" Б/326, 3. ГЕГ-ын даргын 2025.05.20-ны өдрийн "Б.Хишигбагад ёс зүйн хариуцлага ногдуулах тухай" Б/309, 4. ГЕГ-ын даргын 2025.01.21-ний өдрийн "Эрх зүйн чадамжгүй дүгнэлтийг хүчингүй болгох тухай" А/16 дугаар тушаалуудын төслийг боловсруулж шийдвэрийн үндэслэлийг хянаж батлуулсан.			
12	Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах	-Хүчин төгөлдөр бус болгосон дүрэм, журамд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байх. -Хуульд нийцүүлэн дахин боловсруулж, батлуулж мөрдүүлсэн байх. -Тайланд нотломжийг хавсаргасан байх.		1. Мөрдөгдөж байсан дүрэм, журмыг хүчин төгөлдөр болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	Гаалийн харицгаанд мөрдөн хэрэгжүүлдэг УИХ-ын тогтоол, ЗГ-ын тогтоол, СС-ын тушаал, ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан дүрэм, журам, зааварт дүн шинжилгээ хийж, эхний хагас жилд ГЕГ-ын даргын 3 тушаалыг хүчингүй болгоход тус хэлтсийн албан хаагч нартай хамтран ажилласан.		01.01-06.10	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа
	1	2	3	4	5	6
						7

1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	Сургалтын тоо	Зохион байгуулсан 2 удаагийн сургалтад хамрагдсан.	Хууль тогтоомжийн чиглэлээр зохион байгуулагдах сургалтад хамрагдах	Хууль эрх зүйн мэдлэг, мэдээллээ бататгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	01.02-06.10	
2	2025 оноос хос бичгээр албан хэрэгтэй хөтлөхтэй холбогдуулан Монгол бичиг бие даан сурах	Сургалтын тоо	Удирдлагын академийн "Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалт"-д хамрагдаж сертификат авсан.	Байгууллагаас зохион байгуулах болон хөндлөнгийн бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах	Байгууллагаас зохион байгуулсан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. Бие дааж Монгол бичиг судлаж байна.	01.02-06.10	

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛИЙН ХЭЛСТИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

Б.Лувсандорж
..... /Б.ЛУВСАНДОРЖ/

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

**ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ЛУВСАНДОРЖИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Хуулийн хэлтэс

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 4: “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”					
1.	Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт тавьсан байдал	60	10	70	
2.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ	60	10	70	
3.	Хууль, хяналтын байгууллагад Гаалийн байгууллагыг төлөөлөх, хамтран ажилласан байдал	60	10	70	
4.	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах	60	10	70	
5.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт хангах	60	10	70	
6.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	60	10	70	
7.	Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	60	10	70	
8.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
9.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	60	10	70	
10.	Байгууллагын улирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах	60	10	70	
11.	Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн сайд, Засгийн	60	10	70	

газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах				
Дундаж оноо:			70	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	14	14	
2.	2025 оноос хос бичгээр албан хэрэгтэй хөтлөхтэй холбогдуулан Монгол бичиг бие даан сурах	14	14	
Дундаж оноо:			14	

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Асуудал шийдвэрлэх	7	
3.	Хариуцлагатай байдал	7	
4.	Дүн шинжилгээ хийх	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Дундаж оноо:		7	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

№	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо: 8		

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

№	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар(арга хэмжээ)-ын биелэлт орно)	70
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	8
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		99

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:

Хуулийн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

 (Ч.Тамираа)
2025.06.10. (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:


Гаалийн улсын байцаагч

 (Б.Лувсандорж)
2025.06.10. (огноо)

Үнэлгээг хянасан:


Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

 (Г.Энхтайван)
2025.06.25 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:


Хүний нөөцийн хэлтсийн
гаалийн улсын ахлах байцаагч

 (Ө.Тэгшээ)
2025.06.25 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч:

Гаалийн ерөнхий газрын дарга

 (Р.Отгонжаргал)
2025.06.25 (огноо)